

PRAYER, FASTING, AND CONSECRATION | 2023

# Гайхамшгууд

ТҮҮНИЙГ ТАНИУЛ





Гайхамшгууд

**Miracles** ◆

LET HIM BE KNOWN

ТҮҮНИЙГ ТАНИУЛ



**EVERY NATION**



**EVERY NATION**

© 2022 by Every Nation Churches & Ministries. All rights reserved.

Scripture quotations, unless otherwise noted, are from The Holy Bible,  
English Standard Version (ESV) Copyright 2001 by Crossway,  
a publishing ministry of Good News Publishers.

**EveryNation.org/Fasting #ENfast2023**

**Translated to Mongolian by Pastor Oyuna.**

# Агуулга

Мацаг барилтанд бэлдэхүй .....	2
Миний төлөвлөгөө .....	5
Танилцуулга: Гайхамшгуудын зорилго .....	14
Day One: Пентэкост .....	18
Day Two: Эдгэрэл .....	22
Day Three: Хангамж .....	26
Day Four: Удирдамж .....	30
Day Five: Чөлөөлөлт .....	34
Дүгнэлт: Хамгаалалт .....	38

# Мацаг барилтанд бэлдэхүй

## Яагаад мацаг барилт

Мацаг барилт бол Бурханы Өөрийн Хаанчлалаа тэлэх, үндэстнүүдийн хувь тавиланг өөрчлөх, сэргэлтийн галыг бадраах мөн хувь хүний амьдралд ялалтыг авчрахын төлөө хэрэглэдэг сүнслэг зэвсэг юм. Every Nation-ны сүм чуулганууд болон оюутан залуусын үйлчлэл маань жил бүр Бурханы өмнө өөрсдийгөө ариусган даруусаж, ирж буй шинэ цаг мөчийнхөө төлөө Эзэнээс өгөгдөх удирдамж чиглүүлэг, гуйлтын хариулт болон ялалтуудын төлөө мацаг барин залбирдаг билээ.

### Есүс мацаг барьсан.

*Есүс диаволд соригдохоор цөл уруу Сүнсээр хөтлөгдөв. Тэр дөчин өдөр, дөчин шөнө мацаг барьсны эцэст өлсжээ. **Маттай 4:1-2***

*Есүс Сүнсний хүч дотор Галилд буцаж ирэв. Түүний тухай зар эргэн тойрон дахь газар тархсан байлаа. **Лук 4:14***

Есүс энэ дэлхийд ирсэн зорилгоо биелүүлэхэд Түүнд сүнслэг хүч хэрэгтэй гэдгийг мэдэж байсан. Мацаг барилт нь биднийг сүнсээр хүчтэй болгох бөгөөд Бурханы ажлыг хийхэд бэлтгэдэг.

### Мацаг барилт нь даруусах мөн ариусах үйлдэл юм.

*Тэгээд Түүнээс өөрсдийнхөө төлөө болон багачууд, бүх эд хөрөнгөнийхөө төлөө аюулгүй аян замыг гуйхын тулд Бурханыхаа өмнө өөрсдийгөө даруу болгохоор би тэнд Ахава голын дэргэд мацаг барилтыг зарлав. **Езра 8:21***

Бид залбирал болон мацаг барилтаараа Бурханы нигүүлслийг хүлээн авах ба Түүний зүрх сэтгэл рүү нэвтрэн ордог.

### Мацаг барилт биднийг Ариун Сүнсэнд мэдрэмтгий байхад тусалдаг.

*Тэднийг Эзэнд үйлчилж, мацаг барьж байх үед нь Ариун Сүнс “Би Өөрийнхөө ажлыг хийлгэхээр Барнаб, Саул нарыг дуудсан тул тэднийг томилогтун” гэв. **Үйлс 13:2***

Биднийг сатааруулдаг дэлхийлэг зүйлс болон махан биеийн хүслүүдээс татгалзах үед Бурханы дуу хоолойд анхааралтай мэдрэмтгий болдог. Бид ийнхүү Бурханд анхаарлаа илүү сайн төвлөрүүлэх ба Түүний хүсэлд захирагддаг.

## Мацаг барилт сэргэлтийг авчирдаг.

*Танай хүмүүс эрт цагт эвдэрсэн балгаснуудыг дахин сэргээн, олон үеийн сууриудыг босгоно. Тэгээд чамайг "Цөмөрхийг сэргээн босгогч, оршин суух гудамжийг засагч" гэж нэрлэнэ. Исаиа 58:12*

Түүхийн явцад Бурхан мацаг барилт болон залбирлын үр дүнд үндэстнүүдийг сүйрлээс чөлөөлсөн бөгөөд үндэстнүүдэд сэргэлтийг авчирч байсан. Мацаг барилт нь биднийг зуучлал болон залбиралд ялалт байгуулахад тусалдаг.

## Мацаг барилт эрүүл мэндэд тустай.

Мацаг барилт таны хоол боловсруулах системийг хорт бодисоос цэвэрлэнэ. Мөн мацаг барилт нь зарим төрлийн харшил болон өвчнийг эдгээж буйг эмч нар олж илрүүлсэн байдаг. Мацаг барих дэг журмыг дадал болговол бидний амьдралын эрүүл бус зуршлууд зогсоно.

## Мацаг барилтаа төлөвлөх нь

*Тэгээд Иошуа хүмүүст "Өөрсдийгөө ариусгацгаа. Учир нь маргааш ЭЗЭН та нарын дунд гайхамшигт зүйлсийг хийх болно" хэмээв. Иошуа 3:5*

**Залбир** - Мацаг барихын өмнө Библиэ унших цаг гарга. Залбирахдаа Ариун Сүнсний чиглүүлгийг асуу. Та өөрийн үндэстэн, сүм чуулган, найз нөхөд, гэр бүлийнхээ төлөө тодорхой залбирлын сэдэв болон гол итгэлийн зорилтуудаа (faith goals) 6-9ээр хуудсуудад бич.

**Зориул** - Ямар төрлийн мацаг барилтыг сонгох талаар зарбирч, эртнээс өөрийгөө үүнд зориул. Мөн 4 дугаар хуудсанд шийдвэрээ бичиж тэмдэглэ. Энэ шийдвэрээ тууштай дагахын төлөө Бурханы тусламж нигүүлслийг асуун залбир.

**Заавал үйлд** - Мацаг барихаас хэд хоногийн өмнө бага хэмжээгээр идэж эхэл. Өөх тостой, чихэрлэг зүйлсээс татгалз. Мацаг барилтын өдрүүдийн турш нийгмийн оролцоо, биеийн хэт их хөдөлгөөнтэй байдлуудыг хязгаарлахаар төлөвлө. Мацаг барилтын турш чамтай залбирлын хамтрагч байх хэн нэгнийг сонгож түүний гарын үсгийг 5 дугаар хуудсан дээр бичүүл.

**ЖИЧ:** Хэрэв та жирэмсэн, хөхүүл эсвэл эм ууж байгаа бол эмчийн зөвлөгөөг аваарай. Таны нөхцөл байдал бүтэн мацаг барихад тохиромжгүй бол өөрт тань хамгийн сайн тохирох мацгийг тодорхойл.

# Мацаг барилтын үед

*Гэвч Есүс "Хүн зөвхөн талхаар бус, харин Бурханы амнаас гарах үг бүрээр амьдарна" гэж бичигдсэн байдаг гэж хэлэв. Маттай 4:4*

**Анхаарлаа төвлөрүүл** - Мацаг барилтад зориулсан хичээлийг судлан суралцах цаг гарга.

Бурханы Үг болон Ариун Сүнсний удирдамжид хариулт өгөхөд бэлэн бай.

**Залбир** - Мацаг барилтын өдрүүдэд чуулганыхаа нэгдсэн залбиралд боломжоороо хамрагд. Мацаг барилтын турш өөрийн гэр бүл, сүм чуулган, пастор, удирдагчид, үндэстнүүд, оюутан залуус болон илгээлтийн төлөө зуучлан залбир.

**Сэргээн дүүргэ** - Хоол иддэг цагууддаа Бурханы Үгийг илүү их уншиж залбирах цаг гарга. Хангалттай ус ууж, боломжтой бүх цагт сайн амар. Махан бие сульдах, ухаан балартах, тэвчээр алдах, цухалдах гэх мэт сэтгэл санааны таагүй байдлуудад бэлэн байж, тасралтгүй залбирч Эзэний амар тайвнаар дүүргэгд.

## Мацагаа тайлах

*Бид Түүний хүслийн дагуу юуг ч гуйсан, Тэр биднийг сонсдог гэдэг нь Түүний өмнө бидэнд байгаа итгэл зориг юм. Бид юуг ч гуйсан, Тэр биднийг сонсоно гэдгийг бид мэдвэл, бид Түүнээс гуйснаа авсан болохыг мэднэ. 1 Иохан 5:14-15*

**Ид** - Хөнгөн хоол бага багаар ид. Эргээд хэвийн иддэг болтлоо биеэ дасгах хэрэгтэй. Эхлээд жимс, жимсний ундаа, салат, ногоо зэргийг бага порцоор идэх нь тохиромжтой.

**Залбир** - Бүү бууж өг! Бурханы итгэмжтэй байдал болон Түүний цагт хариултууд ирнэ гэдэгт үргэлжлүүлэн итгэ. Шинээр хүлээн авсан Бурханы төлөөх гал цог, хүсэл тэмүүлэлээ энэ оны турш тээж явах мөн Бурхан залбирал гуйлтад тань хариулна гэдэгт итгэлтэй байхын төлөө залбир.



# Миний төлөвлөгөө

## DAY 1

Зөвхөн ус  Зөвхөн шингэн зүйлс  Зөвхөн нэг хоол  Бусад :

Оролцох залбирлын цагууд:

## DAY 2

Зөвхөн ус  Зөвхөн шингэн зүйлс  Зөвхөн нэг хоол  Бусад :

Оролцох залбирлын цагууд:

## DAY 3

Зөвхөн ус  Зөвхөн шингэн зүйлс  Зөвхөн нэг хоол  Бусад :

Оролцох залбирлын цагууд:

## DAY 4

Зөвхөн ус  Зөвхөн шингэн зүйлс  Зөвхөн нэг хоол  Бусад :

Оролцох залбирлын цагууд:

## DAY 5

Зөвхөн ус  Зөвхөн шингэн зүйлс  Зөвхөн нэг хоол  Бусад :

Оролцох залбирлын цагууд:

Би та нарт дахин хэлье. Хэрэв та нараас хоёр чинь ямар нэгэн зүйлийг гуйх талаар газар дээр санаа нийлбэл, тэнгэр дэх Миний Эцэг үүнийг чинь тэдний төлөө биелүүлэх болно. *Маттай 18:19*

Хамтран залбирагч:

# Би Бурханд талархаж байна...

## Хариулагдсан залбирлууд

2022 онд суралцсан зүйлс болон залбирлын хариултуудаа жагсаан бич.

A large grid of dots for writing, consisting of 20 columns and 20 rows of small dots.

# Би 2023 оны турш Бурханд ... итгэж байна.

## Хувийн итгэлийн зорилтууд

Сүнслэг сэргэлт • Эрүүл мэнд • Амжилт ба дүүрэн байдал • Өгөөмөр байдлаар баян байх ...

## Миний гэр бүл

Харилцааны сэргэлт • Гэр бүлийн аврал ...

## Миний боловсрол/албан тушаал

Манлайлал • Тушаал дэвших ...

## Миний Үйлчлэл

Эсийн life-групп өсөх • Ажлынхан ба ангийнхан аврагдах ...

# Би ... төлөө залбирахаар зориулалт гаргана

Нэр

Залбирлын хүсэлтүүд

A large grid of dots for writing, consisting of 20 rows and 30 columns of small dots.





Nations with an Every Nation Church



Nations without an Every Nation Church



# Every Nation одоогоор 80 улс оронд үйлчилж байна.

**Бид Бурханы өгсөн дуудлагын дагуу бүх улс үндэстэнд, оюутан залууст-хүрэх хараатай чуулгануудыг тарихын төлөө урагшилж байна.**

Нэн тэргүүнд Сайн Мэдээг тунхаглахыг зорьдог ба залуу үеийг хараалдаг улс орнуудын төлөө залбирцгаая.


*Numbers as of October 2022.*

**Every Nation-ны  
үйлчлэл хараахан  
байхгүй 115 орнууд  
болон шинэ  
чуулганууд олноор  
таригдах үүд  
хаалгууд  
нээгдэхийн төлөө  
Бурхандаа итгэн  
залбирна уу.**

Afghanistan  
Albania  
Algeria  
Andorra  
Angola  
Antigua and Barbuda  
Argentina  
Azerbaijan  
Bahamas  
Barbados  
Belarus  
Belize  
Benin  
Bosnia and  
Herzegovina  
Bulgaria  
Burkina Faso

Cabo Verde  
Cameroon  
Central African  
Republic  
Chad  
Chile  
Comoros  
Congo  
Costa Rica  
Cuba  
Cyprus  
Democratic Republic  
of the Congo  
Denmark  
Djibouti  
Dominica  
Ecuador

Egypt  
El Salvador  
Equatorial Guinea  
Eritrea  
Estonia  
Ethiopia  
Finland  
Gambia  
Georgia  
Greece  
Grenada  
Guatemala  
Guinea  
Guinea-Bissau  
Guyana  
Haiti  
Honduras



Hungary  
Iceland  
Iraq  
Israel  
Italy  
Jamaica  
Kenya  
Kiribati  
Latvia  
Lebanon  
Lesotho  
Liberia  
Libya  
Liechtenstein  
Lithuania  
Luxembourg  
Macedonia

Madagascar  
Mali  
Malta  
Marshall Islands  
Mauritania  
Micronesia  
Moldova  
Monaco  
Montenegro  
Morocco  
Nauru  
Niger  
North Korea  
Norway  
Palau  
Palestine  
Paraguay

Russia  
Rwanda  
Saint Kitts and Nevis  
Saint Lucia  
Saint Vincent and the  
Grenadines  
Samoa  
San Marino  
São Tomé and Príncipe  
Senegal  
Serbia  
Seychelles  
Sierra Leone  
Slovakia  
Slovenia  
Solomon Islands  
Somalia

South Sudan  
Sudan  
Suriname  
Sweden  
Switzerland  
Syria  
Tanzania  
Tonga  
Trinidad and Tobago  
Tunisia  
Turkmenistan  
Tuvalu  
Uruguay  
Uzbekistan  
Vanuatu  
Vatican City  
Yemen

# элхий даяар 466 чуулган таригдсан ба 119 чуулган одоо идэвхитэйгээр таригдаж байна.

Олон чуулганууд шинээр таригдахын төлөө залби

Дуулал 2:8

С М  
Ж

Чуулганууд  
залбирна уу:

доорх орнуудын

Armenia

Australia

Botswana

Brazil

Cambodia

Canada

China

Colombia

Croatia

Czech Republic

France

Hong Kong

India

Indonesia

Iran

Kazakhstan

Malawi

Malaysia

Maldives

Mauritius

Mexico

Mozambique

Netherlands

New Zealand

Nicaragua

Pakistan

Panama

Philippines

Portugal

Romania

South Africa

Taiwan

Tajikistan

Thailand

Timor-Leste

United Arab Emirates

United Kingdom

United States  
of America

Vietnam

Zambia

Numbers as of October 2022.



# 1,074 тогтворжсон оюутан залуучуудын үйлчлэл ба авралын зар тараалтууд

## Их сургууль кампусаар дамжуулан бүх дэлхийд хүрэх хараа

Тиймээс ургацын Эзэнээс ургацандаа ажилчдыг явуулахыг залбиран гуйцгаа гэж айлдав. *Маттай 9:38*

уудыг г. Учир ыг  
бид ь  
бол ий л удын , уй  
, С М , бөгөөд, э † †  
юм.

- илүү олон оюутнуудад Сайн Мэдээ хүргэх
- Чуулганууд болон оюутны үйлчлэгч нарт Сайн Мэдээ тараах ба дагалдуулахын төлөө мэргэн ухаан өгөгдөх
- Оюутнуудтай холбогдоход тухайн сургуулийн багш ажилчидтай саадгүй харилцах Эзэний таалал
- Шинэ сургуулиудтай ажиллах үүд хаалгууд нээгдэх



## 2023 онд болох Go Conference-ийн төлөө залбир .

2023 онд South Africa -н Cape Town -д Every Nation -ны дэлхий даяарх удирдагч нарын дунд гурван жилд нэг удаа тохиодог " Go Conference" маань болно. Энэ нь хамтдаа Эзэндээ талархан баярлах мөн зэвсэглэгдэх цаг юм. Илүү олон чуулгануудыг тарих болон оюутан залуучуудад хүрэхийн төлөө итгэлээрээ дахин хамтдаа учрах мөчид Бурхан юу хийх бол хэмээн догдолж байна.

Visit [everynation.org/go2023](https://everynation.org/go2023) for more info.



ТАНИЛЦУУЛГА:

# ГАЙХАМШГУУДЫН ЗОРИЛГО

## Үйлс 1:5-8

<sup>5</sup>Иохан усаар баптисм хүртээдэг байсан бол харин та нар ойрын өдрүүдэд Ариун Сүнсээр баптисм хүртэх болно" гэснийг хүлээхийг тэдэнд тушаасан ажгуу. <sup>6</sup> Тэгээд цуглагсад Түүнээс -Эзэн, энэ цагт Та Израильд хаанчлалыг сэргээх үү? гэж асуусанд <sup>7</sup> Тэр тэдэнд - Эцэг Өөрийн эрх мэдлээрээ тогтоосон тэр цаг, үеийг мэдэх нь та нарын хэрэг биш. <sup>8</sup> Харин Ариун Сүнс та нар дээр ирэхэд, та нар хүчийг олж, тэгээд Иерусалим, бүх Иудей, Самари тэр байтугай энэ дэлхийн хязгаар хүртэл Намайг гэрчлэх болно гэв.”

## Унших хэсгүүд:

Маттай 28:16-20; Иеримиа 32:27; Лук 18:27

Үйлс 1:6-11 нь Үйлс номыг хураангуйлан тодорхойлдог хэсэг бөгөөд энд хэлэгдсэн гол сэдэв уг номын турш үргэлжилэн өгүүлэгддэг - Бурханы хүмүүс Түүний Хаанчлалыг тэлэхэд Ариун Сүнс тэднийг чиглүүлэн удирдаж, хүчирхэгжүүлж байдаг. Маттай 28д Есүс дагалдагч нартаа "явж бүх үндэстнийг дагалдагч болгогтун" хэмээн Агуу Захирамжийг өгсөн, Үйлс 1:8д энэхүү чухал даалгаврыг (илгээлт=mission) биелүүлэхэд шаардлагатай хүчийг тэдэнд өгсөн хэмээн өгүүлдэг.

Хуучин гэрээний турш тодорхой цаг үед гайхамшигтай зүйлс хийгдэхийн төлөө хүмүүст Бурханы Сүнс өгөгддөг байсан хэдийч буцаан авагддаг байв. Гэвч Шинэ гэрээнд Христийн амилалтаас хойш, Ариун Сүнс нь Бурханы хүмүүстэй үргэлж хамт байхаар өгөгдсөн. Тэр бидэнтэй хамт байхаар илгээгдсэн.

Есүс дагалдагч нартаа Ариун Сүнсний бэлгээр дамжуулан Өөрийг нь гэрчилэх болон Бурханыг хүндлэн алдаршуулах ер бусын хүч чадлыг өгсөн.

Үйлс ном даяар өгүүлэгдэх түүхүүд нь гайхамшгуудаараа танигдаж тэмдэглэгдсэн. Merriam-Webster толь бичигт гайхамшиг гэдэг үгийг "хүн төрлөхтний амьдрал дахь тэнгэрлэг оролцоо" хэмээн тайлбарласан. Бурхан өнөөдөр ч бидний амьдралд оролцож байна. Тэр Сайн Мэдээний үнэнийг батлахын тулд гайхамшгуудыг үйлдэх дуртай. Бурхан өөрийн хүмүүст хайраа харуулсанаар хүч чадлаа илэрхийлдэг, мөн Өөрийн хүмүүсээр дамжуулан дэлхийд хүчээ харуулдаг.

Гайхамшиг бүхэн Үйлс 1 дүгээр бүлэг дэх илгээлттэй холбоотой байдаг - энэ нь бид Түүний Хүч ба Сайн Мэдээний гэрч болсон явдал юм. Бурхан гайхамшгуудыг үйлддэг нь бид өөрсдөө Түүнийг таниж мэдэхийн төлөө мөн Түүнийг таниулахын тулд юм.

## **Бурхан таны амьдралд тэнгэрлэг арга замаар оролцож тусалсан цаг үеэс хуваалцана уу.**

.....

.....

.....

.....

.....

## **Бурханы хүч чадал ба хайр энэрэлд талархан онцгой залбирах цаг гаргана уу.**

.....


.....

.....

.....

.....





Тэнгэрлэг Аав минь, эмтэрсэн,  
гэмтэй энэ дэлхий дэх бидний  
нөхцөл байдлыг өөрчлөн  
шинэчилдэгт баярлалаа. Таны Үг бол  
Таны хайр, хүч, Сайн Мэдээг  
харуулдаг гайхамшгаар дүүрэн  
билээ. Таныг бүгдийг хийж чаддаг  
гэдэгт бүрэн итгэх зүрхийг минь  
нээж өгөөч. Та Сүр жавхлантай,  
элэгсэг энэрэнгүй, магтаалыг авах  
зохистой. Та миний амьдралд болон  
надаар дамжуулан агуу ажилаа  
хийгээч, би бэлэн байна.

Есүсийн нэрээр

*АМЭН.*

DAY ONE:

# Пентэко́ст

## Acts 2:1–8, 14

<sup>1</sup>Пентекостын өдөр болоход тэд цөмөөрөө нэг газарт цугласан байлаа. <sup>2</sup> Гэнэт тэнгэрээс хүчит хуй салхи мэт дуу чимээ гаран, тэдний суусгааж байсан байр бүхэлдээ тэрхүү дуунд автагджээ. <sup>3</sup> Тэгтэл гал хаялах мэт хэлүүд бий болон хүн нэг бүрийн дээр тогтохыг тэд харлаа. <sup>4</sup> Ийнхүү тэд бүгд Ариун Сүнсээр дүүрч, мөнөөх Сүнсээр дамжуулан өгөгдсөнийг харь хэлээр ярьж эхлэв. <sup>5</sup> Тэр цагт тэнгэрийн доорх үндэстэн бүрээс сүсэгт иудейчүүд Иерусалимд амьдарч байв. <sup>6</sup> Энэхүү дуу чимээнээр үй олон хүмүүс цугларч, өөрсдийнх нь төрөлх хэлээр тэдний ярихыг сонсоод ихэд гайхжээ. <sup>7</sup> Гайхаж алмайрсан тэд -Энэ ярьж байгаа хүмүүс чинь галилчууд биш үү? <sup>8</sup> Гэтэл бид бүгдээрээ өөрсдийн төрөлх хэлээрээ тэдний ярихыг сонсож байх нь юу вэ?

<sup>14</sup> Харин Петр бусад арван нэгийн хамт босож, дуугаа өндөрсгөн, тэдэнд тунхаглан - Иудейн эрчүүд ээ, Иерусалимын бүх оршин суугчид аа! Энэ нь та нарт тодорхой байг. Миний үгэнд анхаарлаа хандуул.

## Унших хэсгүүд:

Үйлс 2:9-41; Египтээс гарсан нь 4:10-12; Исаиа 52:7; Ром 10:14-17

Еврейчүүдийн ёс заншилд Пентэко́ст бол үр тарианы төлөө Бурханд талархадаг баяр юм. Харин Үйлс 2 дугаар бүлэгт дагалдагчид Пентэко́стийн өдөр өөр төрлийн ургацын төлөө баяр тэмдэглэдэг. Энэ бол Сайн Мэдээнд хариу өгсөн хүмүүсийн төлөөх ургацын баяр.

Есүс дагалдагч нартаа Үйлс 1 дүгээр бүлэгт “Дэлхийн төгсгөл хүртэл Түүнийг гэрчилэгч нар байх болно” хэмээсэн бөгөөд Үйлс 2 дугаар бүлэгт Тэр тэдэнд Ариун Сүнсний хүчийг, болон дуудлагаа биелүүлэхэд шаардлагатай бэлэг авьяасыг өгөх болно гэсэн.

Ариун Сүнс бол Бурханы бэлэг, итгэгчидийн дотор, дунд оршидог бөгөөд биднийг зөвхөн итгэлийн амьдралд хүчирхэгжүүлээд зогсохгүй, гайхамшгуудын төлөөх суваг юм. Ариун Сүнсний итгэгчидээр дамжуулан хийдэг бүх гайхамшгууд ба тэмдэгүүд нь биднийг Есүсийн амь амьдрал, үхэл үрүү буцаан авчирдаг.

Агуу Захирамжийг эргэн санацгаая. Есүс дагалдагч нартаа яв, үндэстнүүдийг дагалдуул гэсэн тушаал өгсөн. Энэ нь боломжгүй сонсогдох боловч, бид Бурханы хүч чадалд итгэлтэй мөн дуулгавартай байдлаар найдах хэрэгтэй. Ариун Сүнс биднийг хийж чадахгүй зүйлд хүчирхэгжүүлдэг. Пентэкостын өдөр дагалдагчид энэ гайхамшигтай бэлгийг хүлээн авсан.

Үйлс 2 дугаар бүлгийн эхэнд өгүүлдэг зүйл бол гайхамшиг юм. Ариун Сүнс дагалдагчид дээр буун ирсэнээр тэд харь хэлээр - шинэ хэлүүдээр ярьж - хүн бүр Сайн Мэдээг онцгойгоор сонсов. "Бурханы агуу гайхамшигтай үйлсийг" (Үйлс 2:11) өөрсдийн нутгийн хэлээр ярихыг сонсоод хүн бүр гайхацгаав. Олон хүмүүс цугларч, үл итгэгчид хүртэл болж буй зүйлд гайхширсан. Бурхан Петрт үр нөлөөтэй номлох чадвар өгөн, түүний номлолоор 3,000 хүн гэмшиж Сайн Мэдээг хүлээн авсан!

Энэхүү адилхан бэлэг авьяас, Ариун Сүнсний хүчирхэгжүүлэлт нь өнөөдөр ч боломжтой юм. Гэвч энэ бэлэг авьяас зөвхөн бидний төлөө биш, харин цорын ганц үнэн Бурханыг дэлхий ертөнцөд мэдүүлэхийн тулд юм. Тэр бидэнд Сайн Мэдээг үнэн зөвөөр мөн зоригтойгоор хуваалцах чадварыг өгсөн.

Агуу Захирамжийн дуудлага нь хангалттай зэвсэглэгдээгүй эсвэл бид шаардлагад нийцэхгүй мэт мэдрэмжийг төрүүлэх авч Бурхан бидэнд Өөрийн даалгаврыг (илгээлт=mission) Туслагч - Ариун Сүнсгүйгээр өгөхгүй юм. Бурхан Өөрийн Хаанчлалыг тэлэхийн тулд биднийг гайхамшигт үйлсүүдээрээ дамжуулан хэрэглэдэг.

## **Та Ариун Сүнстэй хувьчилан учирсан уу? Бурхан хэзээ хамгийн сүүлд таныг Өөрийн Сүнсээр дүүргэсэн бэ?**

### **Ариун Сүнсний бэлэг авьяасад түшиглэх нь таны Сайн Мэдээ тараах арга барилыг хэрхэн өөрчилсөн бэ?**





Бурхан минь, Таны Ариун Сүнсний  
бэлгэнд талархаж байна. Би өөрийн  
амьдралдаа Ариун Сүнсийг  
итгэлээрээ хүлээлттэйгээр урьж  
байна. Үр жимстэй илгээлтийн  
амьдралаар зоригтой мөн чин  
сэтгэлээсээ амьдрах хүчийг өгсөнд  
баярлалаа. Сайн Мэдээг хөршүүддээ  
болон үндэстнүүдэд тараах  
дуудлагыг Тань би хүлээн авч байна.  
Та надтай хамт байгааг би мэднэ.  
Хүмүүст Таны Сайн Мэдээний  
нигүүлсэл ба сайн сайхныг  
таниулахын тулд, надад илгээлтийн  
амьдралыг зааж өгөөч.

Есүсийн нэрээр

*А М Е Н .*

DAY TWO:

# ЭДГЭРЭЛ

## Acts 3:1–10

<sup>1</sup> Петр, Иохан нар залбирлын цаг болох есдүгээр цагт сүм уруу явж байв. <sup>2</sup> Төрөлхийн хазгар нэгэн хүнийг хүмүүс авчран сүмийн үзэсгэлэнт хэмээх дааман хаалганы дэргэд суулгаж, тэр хүн өдөр бүр сүмд ирэгсдээс гуйлга гуйдаг байжээ. <sup>3</sup> Петр, Иохан нарыг сүм уруу очиход тэр тэднээс гуйлга гуйж эхлэв. <sup>4</sup> Петр Иоханы хамт түүн уруу харц тогтоон, -Наашаа хар гэв. <sup>5</sup> Тэднийг ямар нэгэн юм өгөх нь хэмээн горьдон, мөнөөх хүн тэдэн уруу анхаарав. <sup>6</sup> Харин Петр түүнд -Надад алт, мөнгө байхгүй. Харин өөрт байгаагаа л би чамд өгье гээд, -Назарын Есүс Христийн нэрээр [босоод] явагтун хэмээн хэлээд <sup>7</sup> баруун гараас нь барьж өндийлгөсөнд түүний хөл, шагай тэр даруй хүч орж, <sup>8</sup> үсрэн цэх зогсоод алхаж эхлэв. Тэр цовхчин Бурханыг магтан тэдний хамт сүмд явж орлоо. <sup>9</sup> Бурханыг магтан алхаж буй түүнийг бүх хүмүүс хараад <sup>10</sup> сүмийн үзэсгэлэнт дааман хаалганы дэргэд гуйлга гуйхаар суудаг байсан нэгэн болохыг таньж, түүнд юу тохиолдсоныг үзээд гайхаж хоцорсон байлаа..

## Унших хэсгүүд:

Лук 5:17-26; Иаков 5:14-15; Иеримиа 17:14

Дээрх түүхийг уншихад дагалдагчдын өнцгөөс харахад амархан байх ч гуйлга гуйж буй хүний зүгээс харвал түүх хэрхэн өөрчлөгдөх бол?

Тэрээр олон жилийн турш хүмүүсээр үүрүүлэн явж сүмийн хаалганы үүдэнд мөнгө гуйдаг байсан. Тэр ажиллах чадваргүй учраас зөвхөн энэ арга замаар амьдарч байв. Тухайн үеийн хуульд "цэвэр бус" хүмүүсийг сүмд орохыг хориглодог байв. Тиймээс тэрээр сүмийн хаалганаас цаашаа нэвтэрч чаддаггүй байсан.

Хэрвээ та энэ гуйлгачин хүнтэй адил байсан бол Бурханыг хэрхэн төсөөлөх байсан бэ? Бурхан үнэхээр оршин байдаг уу? Тэр намайг хардаг уу? Тэр миний нөхцөл байдлыг өөрчлөхийг хүсэж байна уу? Төрөлхийн суунга хүний хувьд өдөр бүр адилхан давтагддаг байсан. Гэвч нэгэн өдөр ганцхан учралаар бүх зүйлс нь өөрчлөгдсөн.

"Над уруу хараач" хэмээн Петр, Иохан хоёр харилцаа үүсгэн өөртэй нь ярихыг тэр гуйлгачин сонссон. Тэрээр тэд түүнд мөнгө өгөх байх хэмээн таамагласан боловч тэрнээс ч илүү агуу зүйлийг хүлээж авах гэж буйгаа мэдэхгүй байв. Петр түүнд "-Надад алт, мөнгө байхгүй. Харин өөрт байгаагаа л би чамд өгье гээд, -Назарын Есүс Христийн нэрээр [босоод] явагтун!..." гэв. (Үйлс 3:6).

Бурханы ер бусын оролцоогоор тэр эдгэрсэн! Гэвч энэ гайхамшигт үйлс түүний махан бие эдгэрэхээс ч илүү агуу зүйл байсан.

Түүний махан биеийн эдгэрэл нь түүнийг босоод магтах мөн цаашлаад урьд өмнө нь огт нэвтрэх боломжгүй байсан сүмд алхан орох боломжтой болгосон. Энэ нь түүнд болон бусад хүмүүст, Бурхан Хүч чадалтайгаас гадна Сайн гэдгийг харуулсан. Тэр Өөрийн хүүхдүүдийг мартдаггүй. Бурхан ийнхүү бидний бодит амьдрал уруу Өөрөө алхан орж ирэн энэ дэлхий дээр мөнхийн улсыг авчирдаг.


Гуйлга гуйгч нэгнийг ажиглаж байсан, гайхамшиг ба тэмдгийг харсан хүмүүс гайхширал бишрэлээр дүүрцгээв. Энэ бол зөвхөн эхлэл. Энэ ер бусын учрал Петрт маш олон хүмүүст номлох үүд хаалгыг нээсэн бөгөөд энэ үйлчлэлээр Үйлс 4:4т хэлсэнчилэн 5000аас ч илүү хүн итгэцгээв.

Энэ түүхэнд харж байгаачилан гайхамшигт үйлс бүхэн үргэлж Бурханыг харуулдаг бөгөөд энэ нь дэлхий ертөнц Түүнийг таньж мэдэхийн төлөө юм.

## **Таны болон таны мэдэх хэн нэгний амьдралд гайхамшгаар эдгэрсэн гэрчлэлийг хуваалцана уу.**

**Та хэн нэгний махан биеийн эдгэрлийн төлөө залбирахад юу саад болж байна вэ?**





Эзэн минь, Та миний эдгээгч гэдэгт  
би итгэж байна. Та сайн бөгөөд хүч  
чадалтай Нэгэн учраас миний  
өвчин, өвдөлт мөн эмтэрсэн,  
гомдсон сэтгэлийг эдгээдэг билээ.  
Таны тусламж хэрэгтэй хүмүүсийг  
харах нүдийг минь нээж өгөөч.

Тэдний эдгэрлийн төлөө  
зоригтойгоор залбирах итгэлийг  
өгөөч. Та нэр алдаршиж, дэлхий  
Таны хүч чадал ба сайн сайхныг  
харах болно хэмээн залбирч байна.

Есүсийн нэрээр

*А М Е Н .*

DAY THREE:

# Хангамж

## Үйлс 4:32-37

<sup>32</sup> Итгэсэн тэдгээр хүмүүс нэг зүрх, сэтгэлтэй байсан бөгөөд тэдний хэн нь ч өөртөө байгаагаа минийх гэдэггүй, харин тэдний бүх юм нь нийтийнх байв. <sup>33</sup> Элч нар Эзэн Есүс [Христийн] амилсныг агуу хүчээр гэрчилж байсан бөгөөд тэдний бүгдийн дээр бялхам их нигүүлсэл байсан болой. <sup>34</sup> Гачигдаж дутагдсан хүн тэдний дунд байсангүй. Учир нь газар, орон байр эзэмшигчид нь цөмөөрөө тэр бүгдээ худалдсан өртгийг нь авчирч, <sup>35</sup> элч нарын хөлд тавихад, тэд хүн бүрд хэрэгцээнийх нь хэрээр хуваарилдаг байлаа. <sup>36</sup> Элч нарт Барнаб (орчуулбал, Тайвшралын Хүү) хэмээн нэрлэгддэг, Кипрт төрсөн Леви овгийн Иосеф нь <sup>37</sup> өмчилж байсан талбайгаа зараад, мөнгийг нь авчран элч нарын хөлд тавьжээ.

## Унших хэсгүүд:

Лук 12:22-31; Египтээс гарсан нь 16:4-16; Филиппой 4:18-19; 2 Коринт 9:6-8

Бурханы Хангамжын төлөөх гайхамшгууд нь цөл дэх маннагаас (Египтээс гарсан нь 16:15) загасны аман дах зоосны (Матай 17:27) тухай түүх гээд Библи даяар өгүүлэгддэг. Түүнчлэн Есүс Эзэн биднийг өдөр тутмынхаа хэрэгцээний төлөө Бурханд найдан залбирхыг заасан, (Лук 11:3)

Бид Бурхан бол хангагч хэмээн баттай итгэх үед бидний төлөөх баялагийн нөөцөөс гартаа атгах нь боломжтой болдог.

Бид итгэлийн амьдралаар өсөх тусам эд баялагийн талаарх бидний ойлголт өөрчлөгддөг. Бид өөрт байгаа зүйлс болон олж чадах орлогоо харахаас илүү, Бурхан биднийг нигүүлсэнгүйгээр эд баялаг болон нөөцүүдийнхээ нярав болдгийг харж эхэлдэг. Тэр бидний хэрэгцээг хангадаг тэгснээрээ бид бусдад ерөөл болох ба тэдний хэрэгцээнд нь тусалдаг. Бурханаас надад өгөгдөж буй бүх зүйлс зөвхөн миний төлөө бус эргэн тойрон дах ах дүүс ба Бурханы гэр бүлийн сайн сайхны төлөө юм.

Гэр бүл доторх бүх зүйлс гэр бүлийн гишүүн бүрт хамааралтай байдаг. Мэдээж хүн бүр нэг шүдний сойз эсвэл нэг оймсоо ээлжлэн хэрэглэхгүй, гэвч буйдан, сандал, зурагт, гал тогооны ширээ гэх мэт хэрэгсэлүүд нь гэр бүлийн гишүүн бүрийн төлөө хэрэглэгддэг. Үйлс 4 дүгээр бүлэгт өгүүлсэн итгэгчдийн адил гэр бүлд "нийтийн хэрэглээ" байдаг.

Дээрх түүхийн гол гайхамшиг "тэдэнд гачигдаж дутагдсан хүн тэдний дунд байсангүй" (Үйлс 4:34) гэдэг нь үнэндээ гайхшруулах зүйл биш байсан. Учир нь тэнд хүчтэй салхи салхилж, тэнгэр элч нар үзэгдэж, газар хөдлөлт болсонгүй, гэвч энэ түүх дэх нөхцөл байдал өөрөө эгэл жирийн биш ер бусын зүйл байв. Энэхүү өгөөмөр байдлын үлгэр дуурайлал нь тэдний эргэн тойрондох ёс заншилаас өөр байсан бөгөөд тухайн хотынхны хувьд бие биенийхээ хэрэгцээнд туслах явдал хэвийн зүйл биш байсан. Харин итгэгчдийн өгөөмөр байдал бол Христийн ер бусын хайр ба хангамжийг харуулсан хүчирхэг илэрхийлэл байсан юм.

Бид бүхэн мөн үүний адил Сүнсээр бялхам дүүрэн амьдрах аваас өгөөмөр байдлын гэрч болж чаддаг. Бурханы агуу нигүүлсэл "таны дээр" (Үйлс 4:33) байгаа нь өгөөмөр байдлын бялхал бөгөөд Бурхан бидний хэрэгтэй бүхэнтэй уулзаж, ер бусын арга замаар хангах болно. Энэ нь бид бусдын хэрэгцээнд хүрч Бурханы Хаанчлалыг тэлэхийн тулд юм.

## **Бурхан таны амьдралыг ер бусын арга замаар ерөөж хангасан үеэс хуваалцана уу?**

**Бурхан таны бүх хэрэгцээг хангаж өгнө гэсэн бат итгэлтэй байсан бол та хэрхэн амьдрах байсан бол?**





Есүс ээ, Та Өөрөө бүх цаг үеийн  
төлөөх хамгийн агуу Хангамж билээ.

Бид өөрсдийгөө аврах ямар ч  
боломжгүй байхад Та миний Аврагч  
болсон. Таныг амьдралын минь бүх  
хэсэгт хангана хэмээн итгэж байна. Та  
намайг ивээдэг учраас би бусдад ерөөл  
болох ба Таны нигүүлслийг харуулах  
болно. Та миний амьдралд мөн надаар  
дамжуулан гайхалтай хангамжуудыг  
өгөх учраас Таны нэр алдар илүү  
ихээр илчлэгдэхийн төлөө залбирч  
байна.

Есүсийн нэрээр

*А М Е Н .*

DAY FOUR:

# Удирдамж

Үйлс 8:26-31, 34-39

<sup>26</sup> Харин Эзэний тэнгэр элч Филипт -Босогтун. Иерусалимаас Газ уруу урууддаг замаар урагш яв гэлээ. (Энэ нь цөлийн зам) <sup>27</sup> Тэр ч босоод явав. Тэгтэл тэнд Етиопын хатан хаан Кандакийн бүх сан хөмрөгийг хариуцагч Етиопын тайган амбан Иерусалимд мөргөл үйлдэхээр ирээд, <sup>28</sup> буцан явж байжээ. Тэр буцах замдаа тэргэндээ эш үзүүлэгч Исаиагийн номыг уншиж явав. <sup>29</sup> Сүнс Филипт хандаж -Тэр тэргийг гүйцэн оч гэв. <sup>30</sup> Гүйн очтол, өнөөх амбан эш үзүүлэгч Исаиагийн номыг уншиж байх нь Филипт сонсдов. Тэгээд түүнээс -Та уншиж байгаагаа ойлгож байна уу? гэж асуухад <sup>31</sup> тэр -Хэн нэгэн зааж өгөхгүй бол би хэрхэн ойлгох билээ? гээд Филиппийг тэргэндээ урьж суулгав.

<sup>34</sup> өнөөх тайган хүн Филипт хандаж -Энэ эш үзүүлэгч хэний тухай яриад байна вэ? Өөрийнхөө тухай ярьж байна уу, аль эсвэл өөр хэн нэгний тухай ярьж байна уу? Надад хэлж өгөөч гэсэнд <sup>35</sup> Филип ам нээн тэрхүү Судраас эхлэн Есүсийн тухай түүнд ярьж өгөв. <sup>36</sup> Тэд замаараа явсаар устай газар хүрч иржээ. Тайган хүн -Хараач, ус байна. Баптисм хүртэхэд болохгүй нь юу билээ гэв. <sup>37</sup> Филип -Хэрэв чи бүх зүрхээрээ итгэвэл, болно гэсэнд тэр -Есүс Христ бол Бурханы Хүү мөн гэдэгт би итгэж байна хэмээн хариулав.] <sup>38</sup> өнөөх тайган хүн тэргийг зогсоохыг тушаав. Тэгээд тэд хоёулаа ус уруу орж, Филип түүнд баптисм хүртээжээ. <sup>39</sup> Тэд уснаас гарч ирэх үед Эзэний Сүнс Филиппийг авч одов. Тайган түүнийг дахин олж хараагүй хэдий ч баяр баясалтайгаар замд гарчээ.

## Унших хэсгүүд:

Дуулал 119:105; Сургаалт үгс 3:5-6; Үйлс 9:10-19; Үйлс 16:6-10

Бурхан Үйлс 8 дугаар бүлэгт Филиппийг Самарт номлож гайхамшгуудыг үйлдэхийн төлөө хэрэглэсэн. Гайхамшиг болон тэмдэгүүд нь маш олон хүнийг гэмшил рүү дагуулсан бөгөөд энэ нь Бурхан хүчирхэг арга замуудаар ажиллагдийн илэрхийлэл юм. Та Филиппийн энэхүү үр жимстэй үйлчлэлийн дараагаар Бурхан түүнийг том хот руу эсвэл олон хүмүүс рүү удирдан дагуулах байх хэмээн бодож магадгүй.

Харин Бурхан Филиппийг хүн явдаггүй зэлүүд замаар удирдан чиглүүлсэн. 26 дугаар ишлэл дээр хэлсэнчилэн Газа бол цөлийн газар байв.

Филиппийн Самарт хийсэн хүчирхэг үйлчлэлийн дараагийн илгээлт бол танихгүй газар уруу мэдэхгүй замаар явах байв. Энэ нь утгагүй мэт боловч Бурхан, хүн бидний бодлоос дээгүүр арга замаар удирдан дагуулдаг. Филип Түүний удирдамжийг дагахаар шийдэх үед Бурхан түүнийг өөрийнх нь бодож төлөвлөснөөс илүү замаар удирдсан.

Хүн бид өдөр бүр том, жижиг олон шийдвэрүүдийг гаргаж байдаг. Харин та амьдарлынхаа төлөө Мөнхийн Бурхан Эзэнээс Түүний хүсэл, төлөвлөгөөг асуувал юу байх бол? Тэр таныг хаашаа илгээх болоо? Таныг хэнтэй уулзуулж, ямар агуу зүйлсийг гүйцэлдүүлэх бол?

Дээрх түүхэнд Бурхан Филиппийг олон түмний дундаас гарган, ганцхан хүнд номлуулахаар цөл дундуур удирдсан. Тэрээр явах замдаа өндөр албаны хүнтэй уулзсан учираад зогсохгүй Бурхан түүнд сударыг тайлбарлах мэргэн ухааныг өгсөн. Бурхан — бүгдийг мэдэгч Альфа ба Омега — биднийг Өөрийн илгээсэн газар бүрт Түүнийг үр дүнтэй гэрчилэх удирдамжийг өгдөг.


Етиопын сангийн яамны сайд буюу нөлөө бүхий тэр нэгэн танигдаагүй газрын танихгүй хүнээр дамжуулан аврагдсан. Энэ гайхамшигт учралаас улбайтайгаар, тэрхүү нэр бүхий хүн өөрийн гэр бүлд, хот тосгонд, цаашлаад үндэстэндээ Сайн Мэдээгээр нөлөөлсөн гэдгийг бодит түүх баталдаг. Бурханы төлөвлөгөө нь бид өөрсдийнхөө төлөө төлөвлөснөөс үргэлж гайхамшигтай байдаг. Түүгээр удирдуулах үед Тэр биднийг төсөөлөөгүй нөхцөл байдалд авчирдаг нь Өөрийн агуу зорилгыг энэ дэлхийд гүйцэлдүүлэхийн тулд юм.

Бурхан удирдан чиглүүлэх гайхамшгаараа дамжуулан, бидэнд хэрэгтэй үед маань хэлэх үг болон шийдэх шийдвэрийг өгдөг.

## **Амьдралдаа чухал шийдвэр гаргах үед тань Бурхан хэрхэн удирдсан бэ?**

### **Таны амьдралын одоогийн нөхцөл байдалд Бурханы удирдамж хэрэгтэй хэсэг байна уу?**





Тэнгэрлэг Аав минь, Та бол Альфа ба  
Омега, түүхүүд бичигдэхээс ч өмнө  
төлөвлөсөн өдрүүдийг болохоос ч  
өмнө мэддэг үүрдийн Бурхан билээ.

Миний амьдралын төлөөх Таны  
зорилгыг биелүүлж, Таны хүслийн  
дагуу амьдрах итгэл болон  
удирдамжыг өгөөч. Таны дуу  
хоолойг сонсоод дуулгавартай  
дагахад туслаач. Явах замыг  
гэрэлтүүлдэг Таны Үг, унахад  
босгодог Таны нигүүлслийн төлөө  
талархаж байна. Намайг энэ  
амьдралыг туулан гарч, Таны төлөө  
амьдрахад удирдаач.  
Есүсийн нэрээр

*АМЭН.*

DAY FIVE:

# Чөлөөлөлт

## Үйлс 16:25-32

<sup>25</sup> Гэвч Паул, Силас хоёр шөнө дундын үед Бурханд залбирч, магтаалын магтууг дуулж байгааг хоригдлууд сонсоцгоож байлаа. <sup>26</sup> Тэгтэл гэнэт шоронгийн суурийг доргиосон хүчтэй газар хөдлөлт болж, даруй бүх хаалганууд нээгдэн хүн бүрийн гав дөнгө нь мултарч унажээ. <sup>27</sup> Хуяг нойрноосоо сэрээд, шоронгийн хаалганууд нээлттэй байхыг харангуутаа хоригдлуудыг оргожээ гэж бодоод өөрийгөө илдээр дүрэн алахыг завдтал <sup>28</sup> Паул чангаар -Амиа бүү хорло. Бид бүгд энд байна хэмээн хашхирсанд <sup>29</sup> тэр -Бамбар авчир гээд, айж чичирсээр орж ирэв. Тэгээд Паул, Силас хоёрын өмнө сөхөрч, <sup>30</sup> тэднийг гаргах зуураа -Ноёд оо, аврагдахын тулд би юу хийх ёстой вэ? гэв. <sup>31</sup> Тэд -Эзэн Есүст итгэгтүн. Чи болон гэрийнхэн чинь ч аврагдана гэлээ. <sup>32</sup> Тэд мөнөөх хүнд болон гэрт нь байсан бүх хүмүүст Эзэний үгийг ярьжээ.

## Унших хэсгүүд:

**Дуулал 150:1-6; Колоссай 3:16; Дуулал 28:1-9; Египтээс гарсан нь 14:13-22**

Паул, Силас хоёр Филипой дах үйлчлэлээсээ болоод шоронд хоригдсон. Тэд олон удаа зодуулж ташуурдуулсны эцэст бусад хориглуудын дунд шаланд хөлийг нь дөнгөлсөн байдалтай шоронд түгжигдсэн. Тэнд ямарч цонх байхгүй тул өдөр ч, шөнө ч адилхан харанхуй бөгөөд тэднийг дөнгөлсөн гинжний чимээ л сонсогдож байв.

Өнөө цаг үед ч мөн адил маш олон итгэгчид шашны хавчлагад өртөх ба итгэлээсээ болж шоронд хоригдож байна. Зарим нь биеэрээ биш ч, сэтгэл зүйн дарамт зовлонд ордог. Ийнхүү бид өөрийн хүчээр гарч чадамгүй хүнд хэцүү үеийг туулж байдаг. Гэвч Бурхан тэдгээр харанхуй цаг үед бидний төлөө гайхамшигт үйлсүүдийг хийдэг.

Паул, Силас хоёр хүнд нөхцөл байдлын дунд Бурхандаа итгэхийг сонгон, Түүнийг магтаж байхад шоронгийн гинжнүүд тасран унасан. Ингээд зогсохгүй энэхүү гайхамшгаар дамжуулан шоронгийн харгалзагч хүртэл чөлөөлөгдсөн.

Энэ ер бусын гайхамшигийг харсан шоронгийн харгалзагчийг дахин гайхшруулсан зүйл бол гинж нь тасарсан хоригдлууд зугталгүй бүгд шорондоо байсан явдал байв. Тэрээр, "Ноёдоо, би аврагдахын тулд юу хийх ёстой вэ?" гэв. Харгалзагч ийнхүү Бурханы Хайр ба Хүчийг харсан. Энэ гайхамшиг шоронгийн харгалзагч болон түүний гэр бүлд үүрдийн нөлөөлтийг авчирсан бөгөөд гэр бүлээрээ аврагдах үүдийг нээсэн юм. Авралын Бурхан бол бидний бие махбод болон сүнс ба зүрх сэтгэлийг бүрэн чөлөөлөх хүч чадалтай Нэгэн юм гэдгийг тэд харсан.

Түүхийг уншихад Ариун Сүнс Паул, Силас хоёрыг шууд дараагийн өглөө нь шоронгоос суллахын тулд тэнгэрлэг арга замаараа зохицуулсан нь гайхшруулдаг. Хэдийгээр боломжгүй нөхцөл байдалд байсан ч Бурхан биднийг хэзээ ч мартдаггүй. Паул, Силас хоёр Бурханд итгэж найдсанаар тэд шоронгоос чөлөөлөгдөөд зогсохгүй, бүхэл бүтэн гэр бүлд Сайн Мэдээ тунхаглагдаж, тэдэнд аврал ирсэн.

**Бурхан таныг харанхуй, хүнд хэцүү нөхцөлөөс чөлөөлж байсан цаг мөч байна уу? Бурханыг хүндлэх цаг гарган Түүний чөлөөлөлтийн төлөө талархан магтана уу?**

.....

.....

.....

**Таны амьдралд Бурханд итгэхэд хэцүү хэсэг байна уу? Тэр танд гуйлтын хариулт болон ялалтуудыг өгнө гэдэгт итгэлтэй байхыг залбир.**


.....

.....

.....







Бурхан минь, Танд боломжгүй зүйл гэж нэг ч үгүй. Та хүнд хэцүү нөхцөлд буй хүмүүсийг бүрэн төгс чөлөөлж өгөөч хэмээн залбирч байна. Та тэднийг бүх төрлийн хүлээснээс аварч, тэрхүү гэрчлэлүүдээр энэ дэлхий Таныг агуу Аврагч хэмээн таниж мэдэх болно гэж тунхаглаж байна. Би Христийн ялалтын эрх чөлөөг хүлээн авч байна мөн Та сүнслэг болон бүх талбарт чөлөөлөлтийг өгөх болно хэмээн итгэж байна.

Есүсийн нэрээр

*АМЭН.*

Дүгнэлт

# Хамгаалалт

## Үйлс 28:1-9

<sup>1</sup> Ийнхүү эсэн мэнд үлдсэн бид уг арлыг Мальт хэмээн нэрлэдгийг мэдэв. <sup>2</sup> Нутгийн хүмүүс бидэнд маш их элэгсэг хандан, бороо цугтаж хүйтэн байсан тул гал өрдөж, бид бүгдийг угтан авав. <sup>3</sup> Паул хэсэг гишүү авчирч галд нэмэхэд, галын халуунаас болж тэдгээрийн дундаас нэгэн хорт могой гарч ирээд түүний гарыг хатгачихав. <sup>4</sup> Нутгийн хүмүүс түүний гараас могой унжин байхыг хараад өөр хоорондоо "Энэ хүн алуурчин гэдэг нь эргэлзээгүй. Тэр тэнгисээс аврагдсан хэдий ч шударга ёс түүнд амьдрахыг зөвшөөрсөнгүй" хэмээн ярьцгаажээ. <sup>5</sup> Гэтэл Паул өөрөө яасан ч үгүй, харин могойг авч галд хаяв. <sup>6</sup> Хүмүүс түүнийг хавагнах, эсвэл газар гэнэт хөсөр унаж үхэхийг нь хүлээж байлаа. Удтал хүлээсний эцэст тэд түүнд ямар ч сонин хачин юм тохиолдохгүй байхыг хараад, бодлоо өөрчилж түүнийг бурхан байж хэмээн ярьж эхлэв. <sup>7</sup> Тэр газрын хавь орчмын нутаг нь арлын тэргүүн Пупли гэгч хүний эзэмшил байсан бөгөөд тэр биднийг найрсгаар хүлээн авч гурав хоног зочилсон билээ. <sup>8</sup> Пуплийн эцэг улаан суулгаар өвдөж, халуураад хэвтэж байлаа. Паул түүн дээр ирж, залбираад түүн дээр гар тавьж түүнийг эдгээв. <sup>9</sup> Энэ явдлын дараа тэр арлынхны дунд өвчтэй байсан бусад хүмүүс түүн уруу ирж, илааршиж байлаа.

## Унших хэсгүүд:

Тооллого 21:6-9; Дуулал 91:13-15; Даниел 6:1-22

Бид мацаг барилт ба залбирлын өдрүүдээрээ Үйлс ном дах зарим гайхамшгуудаас суралцсан. Тэдгээр нь зүгээр нэг үйлдэл биш, харин Бурханы даалгавар (илгээлт = mission) биелэгдэхийн төлөө бид Түүнийг илүү сайн мэдэж, Түүнийг таниулахын тулд юм.

Гэвч Бурханы дуудсан илгээлтийн дагуу Есүсийг даган амьдарч байгаа нь өөрөө аяндаа бидэнд эсэргүүцлийг авчирдаг. Тиймээс Бурханы хамгаалалтын гайхамшиг нь Түүний өгсөн илгээлтийн дагуу амьдрахад бидэнд тайвшрал болон зоригтой байдлыг өгдөг.

Үйлс 28д Паулын Ром уруу явах замдаа сууж явсан усан онгоц Мальт аралд сүйрсэн тухай өгүүлдэг. Тэрээр хорт могойнд хазуулсан боловч гайхамшгаар амьд үлдсэн. Бусад бүх гайхамшгуудаар харагдаж байгаачлан Бурхан зориудаар үйлддэг. Түүний хийдэг гайхамшиг бүхэнд зорилго байдаг. Бурхан Паулыг хамгаалсан, энэ нь Түүний Мальт арал дээр үйлдсэн гайхамшгуудын зөвхөн эхлэл байсан. Паул цаашлаад Пуплийн аавыг эдгээгээд зогсохгүй Сайн Мэдээ номлон, Бурханы хүч чадлыг харуулан арал дээрх өвчтэй хүн бүрийг эдгээв.

Энэхүү "Бурханы хүн төрлөхтний амьдрал дахь тэнгэрлэг оролцоо" нь Паулыг хорт могойноос аврахаас ч илүү агуу байв. Энэ нь тухайн арал дээр Бурханы Алдарын төлөө маш олон хүн эдгэрсэнээр өргөжин тэлэгдсэн юм. Паул Ром уруу аялалаа үргэлжлүүлэхдээ Бурханы хамгаалалтанд итгэн, Сайн Мэдээг саадгүйгээр, зоригтой тунхагласан.

Есүсийг даган амьдрахад бидэнд эсэргүүцэл ирдэг ч мөн энэ нь Бурханы хамгаалалтыг урин дууддаг. Паулыг хорт могойноос аварсны адил Бурхан биднийг дайсны заль мэхнээс хамгаалдаг. Тэр бидэнтэй хамт байдаг учраас бид Түүний төлөө үргэлжлүүлэн амьдарч, Түүнийг илүү их мэдэх ба Түүнийг таниулах болно.

## **Бурхан таныг аюултай нөхцөл байдлаас хамгаалсан цаг мөчийг дурсан Түүнд талархал өргөнө үү.**

**Таны амьдралд Бурханы гайхамшиг хэрэгтэй хэсэг байна уу? Түүний хайр болон хүч чадлын төлөө талархах цаг гаргана уу.**



Бурхан минь, Та гайхамшигт хүч  
чадлаараа энэ дэлхийд хүрч байдагт  
баярлалаа. Таны Ариун Сүнсний  
хүчирхэгжүүлэлт болон бэлгүүдэд  
талархаж байна. Та бол надад хэрэгтэй  
Агуу хүчирхэг Эдгээгч, Хангагч,  
Удирдан чиглүүлэгч, Чөлөөлөгч мөн  
Хамгаалагч билээ. Та Өөрийн Хайраа  
надад гайхамшгуудаар харуулж -  
Таны мутар хөдлөхийг харах нүдийг  
нээж өгөөч. Есүс Христийн Сайн  
Мэдээг тараан, дэлхийд Таны гэрч  
байх зоригийг надад өгөөч. Та надтай  
үргэлж хамт байдагт баярлалаа.

Есүсийн нэрээр

*А М Е Н .*





# Гайхамшгууд



## EVERY NATION

Every Nation is a global family of churches and ministries that exists to honor God by establishing Christ-centered, Spirit-empowered, socially responsible churches and campus ministries in every nation.

**#ENfast2023**

**[EveryNation.org/Fasting](https://EveryNation.org/Fasting)**